

✓

**ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫГ СОНГОХ  
СОНГУУЛИЙН 15 ДУГААР ТОЙРОГ/ БУЯНТ СУМ /-Т БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Т.БАЯРСАЙХАНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Эрхэм зорилго:

**“ХҮНЭЭ ДЭМЖИЖ, ХАМТЫН СЭТГЭЛ, ЗҮТГЭЛЭЭР СУМАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Хөтөлбөрийн зорилго:

Иргэдийнхээ эрх ашгийг дээдэлсэн, тэдний санал санаачилга, хэрэгцээ, шаардлаганд тулгуурласан хөгжлийн бодлогоор сумаа хөгжүүлж, иргэдийн амьдралд дэвшил гаргана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, санхүү

Мөрийн хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалт шаардсан төсөл, арга хэмжээнүүдийг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Ховд аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон бусад хөгжлийн бодлогыг баримт бичгүүдэд тусгуулах, холбогдох салбарын байгууллагууд, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн газруудтай хамтарч ажиллах замаар хэрэгжүүлнэ.

**НЭГ: ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО**

1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, аливаа өвчинг эрт илрүүлэх боломжийг дээшлүүлэх чиглэлд дараах ажлуудыг аймгийн Эрүүл мэндийн газар, БОЭТ болон бусад салбарын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

1.1.1. Сумын Эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангана.

1.1.2. Эрүүл мэндийн төвийн автомашин болон багийн бага эмч нарын унааг шинэчилнэ.

1.1.3. Шүдний явуулын кабинет ажиллуулж цэцэрлэг, сургуулийн хүүхдийн шүд, амны хөндийг эрүүлжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.1.4. Хүн амын эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлэх, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээг сурталчлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.2. Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, сургалт, хүмүүжлийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн дараах ажлуудыг аймгийн Боловсролын газар, төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч хэрэгжүүлнэ.

1.2.1. Цэцэрлэгийн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлж, гадна тоглоомын талбайг сайжруулах замаар хүүхдийн ая тухтай сурч хүмүүжих орчныг бүрдүүлнэ.

1.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ болон ЕБС-д хамрагдах нөхцөлийг төсөл хөтөлбөрийн болон салбарын холбогдох байгууллагуудтай хамтран бүрдүүлнэ.

1.2.3. ЕБС-д “Үдийн хоол” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, чанар, хүртээмжийг сайжруулна.



1.2.4. Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн хангамжийг нэмэгдүүлж, "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх ажлыг төсөл хөтөлбөрийн болон салбарын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

1.2.5. Байгаль орчны салбарын төслийн байгууллагуудад хандаж цэцэрлэг, сургуульд экологийн танхим, булан байгуулж, эко клуб ажиллуулна.

1.3. Үндэсний урлаг, соёл, нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах чиглэлд дараах ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

1.3.1. Соёлын байгууллагад шаардлагатай хувцас, хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.3.2. Сумын Соёлын төвийг түшиглэн урлагийн бүх төрлийн дугуйланг тогтмол чанартай хичээллүүлэн, хүүхэд залуучуудын авьяас чадварыг хөгжүүлнэ.

1.3.3. Иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх, аюулгүй таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, спортын зориулалтын талбай байгуулна.

1.3.4. Хүүхэд, залуучуудын санал санаачилгыг дэмжиж тэдний авьяас сонирхолыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулна.

1.3.5. "Ахмадын өргөө"-г тохижуулж, тэдэнд хүргэх тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд төсөл хөтөлбөрийн болон холбогдох салбарын байгууллагуудтай хамтарч баялаг бүтээгчдийг дэмжинэ.**

2.1. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг хөнгөлттэй урт хугацаатай зээл, хөтөлбөрт хамруулах замаар өрхийн амьжиргааны түвшинг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. /төсөл бичих сургалт зохион байгуулах, үзэсгэлэн худалдаа, тоног төхөөрөмжийн судалгаа хийх г.м/

2.2. Усалгаатай газар тариалан, хүлэмжийн тариалан эрхлэлт, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг дэмжинэ.


2.3. Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хоршоо, бүлгийн зохион байгуулалтанд оруулж, сав баглаа боодлыг шошгожуулах, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногооны үнийг тогтвортой байлгах бодлогыг ХХААГ, салбарын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

2.4. Био /малын гаралтай/ бордоо үйлдвэрлэж, зах зээлд борлуулах ажлыг дэмжинэ.

2.5. Малчдын хоршоо үүсгэн байгуулах, бэхжүүлэх ажлыг дэмжиж, малын гаралтай түүхий эдийн үнийг тогтвортой байлгах, зах зээлд борлуулах, малын гаралтай түүхий эд боловсруулах үйл ажиллагааг дэмжих замаар малдын өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.6. Гахай, зөгийний зэрэг туслах аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

**ГУРАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, ИРГЭДИЙН АМЬДРАХ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ БОДЛОГО**



3.1. Гудамж, талбайг засварлах, тохижуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллага, иргэд, хувийн хэвшлийн дэмжлэгтэй хэрэгжүүлнэ.

3.2. Хог хаягдлийг цуглуулах, зөөвөрлөх, дарж, булж устгах /ландфил/ ажлыг шинэ шатанд гаргах технологи нэвтрүүлэхэд холбогдох талуудтай хамтарч ажиллана.

3.3. Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төсөл хөтөлбөрийн байгуулагуудтай хамтарч олон талт арга хэмжээ зохион байгуулна.

3.4. Гамшгийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлж, ой хээрийн түймэр, үер ус, халдварт өвчин, зуд, барилга байгууламжийн гал түймэр зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлыг ОБГ, холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

**“ХҮНЭЭ ДЭМЖИЖ, ХАМТЫН СЭТГЭЛ,  
ЗҮТГЭЛЭЭР СУМАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн 15 дугаар тойрог/  
Буянт сум /-т бие даан нэр дэвшигч Т.Баярсайханы холбогдох мэдээлэл:

-Бие даан нэр дэвшигчийн овог, нэр

Тэрбишийн Баярсайхан

-Утасны дугаар: 99113516

